



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 38 (611)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Зарим хүмүүсийг одон, медалиар шагнах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл батлах тухай*
- *"Үндэсний дата төв" байгуулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2009 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын хэвлэл

2009 оны аравдугаар сарын 14 № 38 (611)

Улаанбаатар хот

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- | | | | |
|------|---|-----------|-----|
| 502. | Алексей Васильевич Гордеевыг Хөдөлмөрийн гавьяаны
улаан тугийн одонгоор шагнах тухай | Дугаар 73 | 811 |
| 503. | Зарим хүмүүсийг одон, медалиар шагнах тухай | Дугаар 80 | 811 |

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- | | | | |
|------|--|------------|-----|
| 504. | Улсын төсөвт үйлдвэрийн газар байгуулах тухай | Дугаар 174 | 813 |
| 505. | Ажлын үнэлгээ батлах тухай | Дугаар 175 | 813 |
| 506. | Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл батлах тухай | Дугаар 178 | 815 |
| 507. | "Үндэсний дата төв" байгуулах тухай | Дугаар 183 | 818 |
| 508. | Үл хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай | Дугаар 184 | 818 |

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 08 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 73

Улаанбаатар
хот

Алексей Васильевич Гордеевыг Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай
хуулийн 15.1-ийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улс, Оросын Холбооны Улсын
хорооны худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан,
техник, технологийн хамтын ажиллагааг шинэ
агуулгаар баяжуулж, өргөжүүлэн хөгжүүлэхэд

оруулсан үнэтэй хувь нэмрийг нь үнэлж, Оросын
Холбооны Улсын Воронеж мужийн Амбан захирагч
Алексей Васильевич Гордеевыг Хөдөлмөрийн
гавьяаны улаан тугийн одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 08 дугаар
сарын 24-ний өдөр

Дугаар 80

Улаанбаатар
хот

Зарим хүмүүсийг одон, медалиар шагнах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай
хуулийн 15.1-ийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Халхын голын 1939 оны байлдааны
ялалтын 70 жилийн ойг тохиолдуулан Ахмад

дайчид болон Дорнод аймгийн Чойбалсан хотын
үйлдвэрлэл, үйлчилгээ, эрүүл мэнд, хөдөө аж
ахуйн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж
байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар
шагнасугай.

СҮХБААТАРЫН ОДОНГООР:

1. Цагааны Дамдинжав - Нийслэлийн
Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооны өндөр
настан, ахмад дайчин

2. Жигмэдийн Үнэнбат - Нийслэлийн

Баянгол дүүргийн 12 дугаар хорооны өндөр настан,
ахмад дайчин

3. Нямын Сүрэн - Нийслэлийн Баянзүрх
дүүргийн 1 дүгээр хорооны өндөр настан, ахмад
дайчин

ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Смирнов Александр Иванович - ОХУ-ын Москва хотын иргэн, Монголын найрамдлын нийгэмлэгийн гишүүн, Халхын голын дайны ахмад дайчдын товчооны Монголын хэсгийн гишүүн, ЗХУ-ын баатар, чөлөөнд байгаа хурандаа

2. Дэндэвийн Ням - Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын өндөр настан, ахмад дайчин

3. Дамираннын Жамъян - Нийслэлийн Баянзүрх дүүрэг, 14 дүгээр хороо, Халхын голын байлдааны ахмад дайчин

4. Сономын Цэвэлдорж - Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 14 дүгээр хорооны өндөр настан, ахмад дайчин

5. Шархүүгийн Цоохүү - Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын өндөр настан, ахмад дайчин

6. Дамбын Намнан - Архангай аймгийн Эрдэнэмандал сумын өндөр настан, ахмад дайчин

7. Жамсрангийн Цэвээн - Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын өндөр настан, ахмад дайчин

8. Тамжидын Гэндэн - Нийслэлийн Хан-Уул дүүргийн 9 дүгээр хорооны өндөр настан, ахмад дайчин

9. Буниагийн Аюурзана - Нийслэлийн Баянгол дүүргийн 5 дугаар хорооны өндөр настан, ахмад дайчин

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Үржингийн Төмөрбаатар - "Дорнод гурил" ХХК-ийн бригадын дарга

2. Маамын Уртнасан - "Дорнод гурил" ХХК-ийн Тариа бригадын дарга

ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ ОДОНГООР:

1. Сономдоогийн Намжил - Төв аймгийн Жаргалант сумын өндөр настан, ахмад дайчин

2. Очирын Лааган - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 5 дугаар хорооны өндөр настан, ахмад дайчин

3. Дамдингийн Лувсанбазар - Нийслэлийн Баянзүрх дүүрэг, 12 дугаар хорооны өндөр настан, Халхын голын байлдааны ахмад дайчин

4. Шагдарын Санжаа - Нийслэлийн Баянзүрх дүүрэг, 14 дүгээр хорооны өндөр настан, Халхын голын байлдааны ахмад дайчин

5. Ганин Николай Иванович - ОХУ-ын Москва хотын иргэн, Халхын голын байлдааны ахмад дайчин, чөлөөнд байгаа хурандаа

6. Дашдоржийн Санжав - Булган аймгийн Могод сумын өндөр настан, 1939 оны ахмад дайчин

7. Сүрэнхорлоогийн Дашдэндэв - Дархан-Уул аймгийн Дархан сумын өндөр настан, ахмад дайчин

8. Дамбын Дашзвэг - Өвөрхангай аймгийн Хархорин сумын өндөр настан, ахмад дайчин

9. Хорхойн Уудай - Увс аймгийн Малчин сумын өндөр настан, ахмад дайчин

10. Ямпилийн Дамдинсүрэн - Ховд аймгийн Зэрэг сумын өндөр настан, ахмад дайчин

11. Гончигийн Галсан - Ховд аймгийн Цэцэг сумын өндөр настан, ахмад дайчин

12. Гомбын Шаравдорж - Нийслэлийн Баянгол дүүргийн 11 дүгээр хорооны өндөр настан, ахмад дайчин

13. Должингийн Дэмбэрэл - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны өндөр настан, ахмад дайчин

14. Чимидийн Лхүндэв - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 12 дугаар хорооны өндөр настан, ахмад дайчин

15. Сүрэнгийн Лхамжав - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны өндөр настан, ахмад дайчин

16. Мөнх-Очирын Наран - Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны өндөр настан, ахмад дайчин

17. Огнонгийн Сумъяа - Нийслэлийн Баянзүрх дүүргийн 7 дугаар хорооны өндөр настан, ахмад дайчин

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Горбатко Виктор Васильевич - Монголын найрамдлын нийгэмлэгийн тэргүүн, ЗХУ-ын Сансрын нисгэгч, ЗХУ-ын 2 удаагийн баатар, Монгол Улсын баатар

2. Бабушкин Владимир Алексеевич - Монголын найрамдлын нийгэмлэгийн дэд тэргүүн, хариуцлагатай нарийн бичгийн дарга

3. Богданов Николай Григорьевич - ОХУ-ын Москва хотын иргэн, Халхын голын байлдааны ахмад дайчин, чөлөөнд байгаа хурандаа

4. Кравец Николай Дорфеевич - ОХУ-ын Москва хотын иргэн, Халхын голын байлдааны

ахмад дайчин, чөлөөнд байгаа хошууч генерал

5. Смирнов Владимир Васильевич - ОХУ-ын Москва хотын иргэн, Халхын голын байлдааны ахмад дайчин, чөлөөнд байгаа хурандаа

6. Цэрэнчимэдийн Ганбат - Дорнод аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн захирал

7. Дагвын Дуламжав - Дорнод аймгийн худалдаа, үйлчилгээний "Хос өргөө" ХХК-ийн захирал

8. Адьяагийн Равдан - Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын 1 дүгээр багийн малчин

9. Сурмаагийн Энхбаяр - "Дорнод гурил" ХХК-ийн цахилгааны инженер



ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Галсантавахайн Хүрэлбаатар - Дорнод аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн мэс заслын их эмч

"НАЙРАМДАЛ" МЕДАЛИАР:

1. Бондаренко Александр Федорович - Нийгэмлэгийн удирдлагын гишүүн, дэмжигч

2. Лалин Владимир Иванович - Монголын найрамдлын нийгэмлэгийн удирдлагын гишүүн, дэмжигч

3. Шульгинов Николай Григорьевич - Монголын найрамдлын нийгэмлэгийн Тэргүүлэгч гишүүн, дэмжигч

4. Голубева Ирина Евгеньевна - Украин Улсын Киев хотын Захиргааны ажилтан

5. Ишунина Наталья Владимировна - Найрамдлын холбооны байгууллагын ажилтан

6. Нетак Виктор Николаевич - Украины Олон улсын дайнд оролцогчдын зөвлөлийн ажилтан

7. Савин Иван Федорович - Украины Ахмад дайчдын зөвлөлийн ажилтан

8. Селиванов Геннадий Михайлович - Киевийн Захиргааны ажилтан

9. Перевертайло Вячеслав Исидорович - Монголын найрамдлын нийгэмлэгийн тэргүүлэгч гишүүн, дэмжигч

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 06 дугаар сарын 10-ны өдөр

Дугаар 174

Улаанбаатар хот

Улсын төсөвт үйлдвэрийн газар байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь заалт, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 15.1.7-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори болон Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лабораторийг одоо байгаа материаллаг баазыг нь түшиглүүлэн улсын

төсөвт үйлдвэрийн газар болгон тус тус өөрчлөн байгуулсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН
ШАДАР САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Т.БАДАМЖУНАЙ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 06 дугаар сарын 17-ны өдөр

Дугаар 175

Улаанбаатар хот

Ажлын үнэлгээ батлах тухай

Газрын тухай хуулийн 24.3, 58.8 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Газар зохион байгуулалт, газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх ажлын үнэлгээ-г хавсралт ёсоор баталсугай.

2. Хэрэглээний үнийн индекс 15-аас дээш хувиар өсч, буурах тохиолдолд ажлын үнэлгээг шинэчлэн батлуулах арга хэмжээ авч байхыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулгад даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Аргачлал, үнэлгээ батлах тухай" Засгийн газрын 2003 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 103 дугаар тогтоолын 1, 2 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАЯР

**ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН САЙД**

Х.БАТТУЛГА

Засгийн газрын 2009 оны 175 дугаар
тогтоолын хавсралт

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН УЛСЫН ХЯНАН БАТАЛГАА ХИЙХ АЖЛЫН ҮНЭЛГЭЭ

№	Ажлын нэр	Ажлын зэрэглэл ба төрөл	Төлөвлөгөөт ажил	
			Хэмжих нэгж	Үнэлгээ (төг)
1. Хилийн цэс тогтоох, тодотгох				
1.1	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, улсын тусгай хэрэгцээний газрын хилийн цэс шинээр тогтоох	I	1000 га	5147
		II	1000 га	6434
		III	1000 га	7721
1.2	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, улсын тусгай хэрэгцээний газрын хилийн цэс тодотгох, өөрчлөлт оруулах	I	1000 га	2856
		II	1000 га	3570
		III	1000 га	4285
2. Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах				
2.1	Сумын	I	1000 га	3634
		II	1000 га	5451
		III	1000 га	7268
2.2	Нийслэл, дүүргийн	I	1000 га	7635
		II	1000 га	11453
		III	1000 га	15270
3. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах				
3.1	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө шинээр боловсруулах	I	1000 га	3996
		II	1000 га	4995
		III	1000 га	5993
3.2	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг тодотгох, өөрчлөлт оруулах	I	1000 га	2997
		II	1000 га	3746
		III	1000 га	4495
3.3	Нийслэл болон улсын зэрэглэлтэй хотуудын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулах	I	1 га	421
		II	1 га	163
		III	1 га	151
3.4	Нийслэл болон улсын зэрэглэлтэй хотуудын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг тодотгох, өөрчлөлт оруулах	I	1 га	350
		II	1 га	280
		III	1 га	220
3.5	Бүс нутгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулах	I	1000 га	4000
		II	1000 га	7353
		III	1000 га	6149
		IV	1000 га	3894
3.6	Бүс нутгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг тодотгох, өөрчлөлт оруулах	I	1000 га	2414
		II	1000 га	5515
		III	1000 га	4612
		IV	1000 га	2920
3.7	Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулах	I	1000 га	3614
		II	1000 га	3120
		III	1000 га	3998
3.8	Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг тодотгох, өөрчлөлт оруулах	I	1000 га	3787
		II	1000 га	2340
		III	1000 га	2998
4. Газрын нэгдмэл сангийн ангилал тогтоох				
4.1	Газрын нэгдмэл сангийн ангилал тогтоох	I	1000 га	7936
		II	1000 га	9687
		III	1000 га	11671
4.2		Нийслэл болон улсын зэрэглэлтэй хотуудад	1000 га	101603

5. Газрын улсын бүртгэлийн ажлын үнэлгээ					
5.1	Кадастрын зураглалын ажлыг төлөвлөж төсөл буюу техникийн даалгавар бичих	1:1000	100 га	37680	
		1:2000	100 га	46980	
		1:25000	1000 га	62475	
5.2	Зураглалын үндэслэлийн цэг төвлөрсөн журмаар бэлтгэх		цэг	14234	
	Нэгж талбарын эргэлтийн цэгийн төвийг бэлтгэх		төв	8546	
5.3	Зураглалын үндэслэлийн цэг тэмдэгтийг газарт бэхлэх		цэг	8508	
	Нэгж талбарын эргэлтийн цэгийг газарт бэхлэх		эргэлтийн цэг	5316	
5.4	Кадастрын хэмжилт, зураглал болон боловсруулалт хийх	I	эргэлтийн цэг	5924	
		II	эргэлтийн цэг	11259	
		III	эргэлтийн цэг	16593	
5.5	Газрын улсын бүртгэлийн мэдээллийг кадастрын зурагтай холбож газрын кадастрын мэдээллийн санд оруулах		нэгж талбар	2860	
5.6	Нэгж талбарын хувийн хэргийг шинээр үүсгэж, баталгаажуулах		нэгж талбар	8430	
6. Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа					
6.1	Хөдөө аж ахуйн газрын	Хадлангийн газрын		1 га	90
		Бэлчээрийн газрын	I	1 га	6
			II	1 га	7
			III	1 га	10
		Тариалангийн газрын		1 га	250
Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, тэжээлийн ургамал тариалсан газрын		1 га	1400		
6.2	Тусгай хамгаалалттай газрын	I	1 га	6	
		II	1 га	10	
		III	1 га	12	
6.3	Хот, тосгон бусад суурин газрын	Барилга байгууламж, нийтийн эдлэлбэрийн газар		1 га	800
		Гэр хороолол, үйлдвэр, аж ахуйн зориулалт бүхий газар		1 га	1200
		Уурхайн газар		1 га	1800
7. Газрын нөхөн сэргээлт					
7.1	Хүчтэй элэгдэж эвдэрсэн тариалангийн газрын		1 га	140000	

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 06 дугаар сарын 10-ны өдөр

Дугаар 178

Улаанбаатар хот

Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд Н.Алтанхуяг, Сангийн сайд С.Баярцогт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Зам, тээвэр, барилга, нь:

1. "Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл"-ийг хавсралт ёсоор баталсугай.
2. Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлийг хэрэгжүүлэх орчинг бүрдүүлж, зохион

хот байгуулалтын сайд Х.Баттулга нарт үүрэг болгосугай.

3. Монгол Улсын төсөвт жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлээр тусгагдсан хөрөнгийн эх үүсвэрийг "Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл"-ийг хэрэгжүүлэх зорилгод нийцүүлэн зарцуулахыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд Н.Алтанхуяг, Шадар сайд М.Энхболд, Сангийн сайд С.Баярцогт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай нарт даалгасугай.

4. "Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл"-ийг хэрэгжүүлэх ажлыг тухайн нутаг дэвсгэртээ зохион байгуулж, хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд боломжтой бүхий л хэлбэрээр дэмжлэг үзүүлж ажиллахыг

аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2003 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 188 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД** **С.БАЯР**

**МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН
ШАДАР САЙД** **Н.АЛТАНХУЯГ**

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН САЙД** **Т.БАДАМЖУНАЙ**

**Засгийн газрын 2009 оны 178 дугаар
тогтоолын хавсралт**

ОРОН НУТАГТ ҮЙЛДВЭРЛЭЛ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль болон аймгуудын онцлог, эрэлт хэрэгцээнд нийцсэн жижиг үйлдвэр, үйлдвэрлэл технологийн паркийг байгуулж, орон нутгийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2008-2012 он)-т тусгасан зорилт болон Засгийн газраас 2009 оныг "Үйлдвэржүүлэлтийг дэмжих жил" болгон зарласан нь энэхүү чиглэлийг боловсруулах үндэслэл болж байна.

Хоёр. Зарчим

2. Энэхүү чиглэлийг хэрэгжүүлэхдээ дараахь зарчмыг баримтална:

1. Орон нутгийн бодит хэрэгцээ шаардлагад үндэслэсэн хуулийн этгээд, иргэдийн бүтээлч санал, санаачилгыг дэмжих;
2. Төр, олон нийт, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлах;
- 2.3. Төсөл шалгаруулах, ил тод байдлыг эрхэмлэх;
- 2.4. Санхүүгийн эх үүсвэрийг зохистой зарцуулах.

Гурав. Зорилго

3. Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлийн зорилго нь үйлдвэржүүлэлтийг хөгжүүлэх нутгийн хөгжлийн чиг баримжаа болж, хөдөөд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх замаар орон нутгийн бие даасан байдлыг дэмжих явдал мөн.

Дөрөв. Зорилт

4. Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлийн зорилгыг биелүүлэх хүрээнд дараахь зорилтыг хэрэгжүүлнэ:

- 4.1. Орон нутгийн түүхий эд, нөөц боломжид тулгуурласан үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх;
- 4.2. Улс, бүс нутгийн чанартай үйлдвэрүүд байгуулах.

Тав. Хэрэгжүүлэх арга хэмжээ

5. Орон нутгийн түүхий эд, нөөц боломжид тулгуурласан үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх

зорилтын хүрээнд дараахь жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ, аж ахуйг шинээр байгуулж, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг өргөтгөхөд дэмжлэг үзүүлнэ:

5.1. Махны анхан шатны боловсруулалтын үйлдвэрийг Баянхонгор, Говь-Алтай, Дундговь аймагт байгуулах;

5.2. Мал бордох аж ахуйг Булган, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл, Хэнтий аймагт байгуулах;

5.3. Цөм сүргийн үржлийн төв бүхий Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорнод, Дундговь, Завхан, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймагт шилмэл сүргийн аж ахуй байгуулах;

5.4. Сүү боловсруулах цөхжий аймаг тус бүрт нэг суманд сүү боловсруулах үйлдвэрийг Архангай, Баянхонгор, Хөвсгөл, Дорнод аймаг, сүү хөргөөх цэг, хөргөлтийн төвийг Архангай, Булган, Дархан-Уул, Дундговь, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ /2/, Төв, Хөвсгөл аймаг, Улаанбаатар хотод тус тус шинээр байгуулах;

5.5. Аймгуудад тус бүр 50 үнээтэй сүүний чиглэлийн фермерийн аж ахуйг, бэлчээр болон тэжээлийн нөөц бүхий аймагт сүүний чиглэлийн аж ахуй тус тус байгуулах;

5.6. Тэжээлийн аж ахуй, үйлдвэрийг Архангай, Баян-Өлгий, Говь-Алтай, Дархан-Уул, Дорнод, Өвөрхангай, Сүхбаатар, Төв, Увс, Ховд аймагт байгуулах;

5.7. Хүлэмжийн аж ахуйг бүх суманд байгуулах;

5.8. Хүнсний ногоо боловсруулан савлах үйлдвэр, цех Орхон, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Ховд аймагт байгуулах, одоо хуйгааг нь өргөтгөх;

5.9. Төмс, хүнсний ногоо хадгалах механикжсан зоорь, хүлэмжийн төвлөрсөн аж ахуйг Улаанбаатар хотод байгуулах, барих;

5.10. Жимс, жимсгэнэ, чацгараны аж ахуйг байгаль, цаг уурын тохиромжтой нөхцөл бүхий аймагт байгуулах;

5.11. Жимс, жимсгэнэ боловсруулан савлах үйлдвэр, цехийг Архангай, Завхан, Орхон, Сэлэнгэ, Төв, Увс, Хэнтий, Хөвсгөл аймагт байгуулах, өргөтгөх;

5.12. Давсны үйлдвэр Дорнод, Завхан, Увс, Төв аймаг, Улаанбаатар хотод байгуулах;

5.13. Цардуулын үйлдвэр Сэлэнгэ, Төв, Ховд аймагт байгуулах;

5.14. Балт ургамлын хүрэлцээтэй нөөц боломж бүхий аймгуудад зөгийн аж ахуй байгуулах, өргөтгөх;

5.15. Загас үржүүлгийн аж ахуйг Архангай, Говь-Алтай, Завхан, Ховд, Хөвсгөл аймагт байгуулах;

5.16. Шувууны аж ахуйг аймаг бүрт болон Улаанбаатар хотод байгуулах, өргөтгөх;

5.17. Аймаг, сумдад ахуй үйлчилгээний төв, цэг байгуулах;

5.18. Ноос угаах болон эсгийний үйлдвэр, оёдлын үйлдвэрийг аймаг бүрт байгуулах;

5.19. Модон эдлэлийн үйлдвэрийг Архангай, Булган, Дорнод, Завхан, Өмнөговь, Сэлэнгэ, Хөвсгөл аймагт байгуулах, өргөтгөх;

5.20. Чулуу боловсруулах үйлдвэр, цехийг Дорноговь, Орхон, Ховд аймагт байгуулах;

5.21. Хаягдал цаас, сав баглаа боодлын үйлдвэрийг байршлыг нь сонгох замаар байгуулах;

5.22. Электрон, цахилгаан тоног төхөөрөмжийн үйлдвэрийг Дархан-Уул, Төв аймагт байгуулах;

5.23. Шингэн түлш савлах үйлдвэрийг Увс, Ховд аймагт, шахмал болон утаагүй түлшний үйлдвэрийг Дархан-Уул, Орхон аймаг, Улаанбаатар хотод байгуулах;

5.24. Орон нутгийн түүхий эзэд тулгууласан арматур, төмөр хийцийн жижиг үйлдвэр, цехийг Дархан-Уул, Орхон, Дорнод аймагт байгуулах, өргөтгөх;

5.25. Экспортын баримжаатай болон импорт орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэх жижиг, дунд үйлдвэрийг Улаанбаатар хот, Дархан-Уул, Орхон болон бусад аймгуудад байгуулах;

5.26. Хог боловсруулах туршилтын үйлдвэрийг Улаанбаатар хот, Баянхонгор аймагт байгуулах.

6. Улс, бүс нутгийн чанартай үйлдвэр байгуулах зорилтын хүрээнд дараахь үйлдвэрүүдийг байгуулах буюу үйл ажиллагааг нь сэргээхэд дэмжлэг үзүүлнэ:

6.1. Дорноговь аймагт 1 сая хүртэл тонн цемент үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэр, Баянхонгор, Говь-Алтай, Хэнтий аймагт орон нутгийн түүхий эзэд тулгуурласан цементийн жижиг үйлдвэр байгуулах;

6.2. Барилгын шилний үйлдвэр байгуулах;

6.3. Төвийн болон хангайн бүсэд төмөрлөгийн үйлдвэр байгуулах;

6.4. Өндөр технологийн үйлдвэрүүдийг байрлал сонгон байгуулах;

6.5. Ноолуурыг ээрмэл хүртэл боловсруулах үйлдвэрийг бүсүүдэд байгуулах;

6.6. Ноос боловсруулах үйлдвэр, цехийг бүсүүдэд байгуулах;

6.7. Бүс нутгийн чанартай сүү боловсруулах үйлдвэр байгуулах;

6.8. Бүсийн мах боловсруулах үйлдвэрийг түшиглүүлэн махыг гүн боловсруулах цех байгуулах, өргөтгөх;

6.9. Зоорийн болон агуулахын аж ахуй байгуулах.

Зургаа. Удирдлага, зохион байгуулалт, хяналт

7. Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлийг хэрэгжүүлэх ажлыг Монгол Улсын Тэргүүн шадар сайдаар ахлуулсан Үйлдвэржүүлэлтийн жилийн ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсэг холбогдох яам, аймаг, нийслэлийн Засаг даргатай хамтран зохион байгуулна.

8. Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Монгол Улсын Тэргүүн шадар сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд бүр батлан мөрдөж ажиллана.

9. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам энэхүү чиглэл болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтэд улсын хэмжээнд хяналт тавьж зохицуулан, бодлогын удирдамж, арга зүйгээр хангана.

10. Нийслэл болон аймагт нутгийн захиргаа, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөл бүхий үйлдвэр хөгжүүлэх чиглэл хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах салбар ажлын хэсэг ажиллана. Ажлын хэсгийг аймаг, нийслэлийн Засаг дарга буюу Засаг даргын орлогч ахална.

Долоо. Хэрэгжүүлэх хугацаа

11. Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлийг 2009-2012 онд хэрэгжүүлнэ.

Найм. Хөрөнгийн эх үүсвэр

12. "Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл"-ийг хэрэгжүүлэхэд дарсахь хөрөнгийн эх үүсвэрийг ашиглана:

12.1. Иргэд, аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгө;

12.2. Банкны зээл;

12.3. Улсын болон орон нутгийн төсөвт үйлдвэржүүлэлт, жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр тусгагдсан хөрөнгө;

12.4. Гадаад орон, олон улсын байгууллагын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж;

12.5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө;

12.6. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгө;

12.7. Бусад.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 06 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 183

Улаанбаатар хот

"Үндэсний дата төв" байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь заалт, Тагнуулын байгууллагын тухай хуулийн 11.1.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Үндэсний дата төв" улсын төсөвт үйлдвэрийн газрыг Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын даргын дэргэд байгуулсугай.

2. "Үндэсний дата төв"-ийн техник, технологийн удирдлагыг Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газарт, үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах чиг үүргийг Тагнуулын ерөнхий газарт тус тус хариуцуулсугай.

3. "Үндэсний дата төв"-ийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг зохих журмын дагуу баталж улсын бүртгэлд бүртгүүлэхийг Төрийн өмчийн хороо (Д.Сугар), Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо,

технологийн газрын дарга Ж.Сансар, Тагнуулын ерөнхий газрын дарга Р.Болд нарт даалгасугай.

4. "Үндэсний дата төв"-ийн үйл ажиллагааны зардал болон аюулгүй байдлыг хангахад шаардагдах хөрөнгийг Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд тусган шийдвэрлэж, цаашид зардлыг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогт, Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газрын дарга Ж.Сансар, Тагнуулын ерөнхий газрын дарга Р.Болд нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

Б.ДОЛГОР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 06 дугаар сарын 24-ний өдөр

Дугаар 184

Улаанбаатар хот

Үл хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Балансаас балансад шилжүүлэх үл хөдлөх хөрөнгийн жагсаалтыг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөрөнгө шилжүүлэх ажлыг зохих журмын

дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн хороо (Д.Сугар)-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

Б.ДОЛГОР

Засгийн газрын 2009 оны 184 дүгээр тогтоолын хавсралт

ШИЛЖҮҮЛЭХ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

№	Үл хөдлөх хөрөнгийн нэр	Байршил	Ашиглалтад орсон он	Балансын үнэ (мян.төг)	Эзэмшигч байгууллагын нэр	Шилжүүлэн авах байгууллагын нэр
1	Нисэх буудлын зорчигч, үйлчилгээний барилга	Завхан Улиастай	1985	5.500.00	Иргэний нисэхийн ерөнхий газар	"Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК
2	Нисэх буудлын машины гарааш 2		1986	880.60		
3	Нисэх буудлын машины гарааш 1		1991	36.60		
4	Нисэх буудлын агуулахын барилга		1992	55.60		
5	Нисэх буудлын уурын зуухны барилга		1989	10.443.40		
НИЙТ ДҮН				19.906.20		

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн редакци.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон-128 тоот
и-мэйл: tunin_medeefel@parliament.mn

☎ 262420, 329612
Индекс 14303

☎ 329467

Хэвлэлийн хуудас 1